



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А184

Сангиндалай

Газар эзэмших эрхийг хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 7-р багийн нутаг дэвсгэрт Шинэ эмнэлгийн баруун талд Өвөр угтаал 1-124, 1-126 тоот хаягт байрлалтай 4815003559, 4815003560 нэгж талбарын дугаартай тус тус 300м.кв талбайтай үйлчилгээний зориулалттай олгосон газрын газар эзэмшигч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2жил дараалан ашиглаагүй тул газар эзэмшигч Чимэддоржийн Онцчухал (ЗП75112813)-ын газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.

2. Газар эзэмших эрхийг хүчингүй болгосон талаар Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу Ч.Онцчухал-д мэдэгдэж газар эзэмшүүлэх гэрээг цуцлахыг газрын даамал (Э.Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/47, 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/55 дугаар захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



О.БАЗАРРАГЧАА

482302167